


**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2022 оны 11 дугаар сарын 23

Багануур дүүрэг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
НЭГ.ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛЭХ			
1.	Ажлын байранд өглөө 11:00, өдрийн 15:00 цагуудад 10-15 минутын дасгал хөдөлгөөнийг өдөр бүр зохион байгуулах	<p>Дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн-эрүүл мэнд” биеийн тамир спортын 8 дугаар наадам, “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цом аялуулах аяны удирдамжийн хүрээнд Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийдэг болсон. Мөн биеийн тамир спортын 8 дугаар наадамын хаалтыг Ажлын байрны дасгал хөдөлгөөнөөр 2022 оны 06 дугаар сарын 04 ний өдөр зохион байгуулагдаж хаалаа.</p> <p>7, 8 дугаар сард албан хаагчдын ээлжийн амралттай үе бөгөөд 9 дүгээр сараас эхлэн ажлын байрны дасгал хөдөлгөөнийг идэвхээлэн хийж тогтмолжуулаад байна. Мөн зарим албан хаагчид өглөө эртлэн алхах, сбиненд явах, бүжгийн сургалт болон одон бөмбөгөөр хичээллэх зэргээр 3-4 албан хаагч байнгын дасгал хөдөлгөөнийг өөрийн сонирхлоор сургалт, болон бусад хэлбэрээр хийдэг болсон</p>	100%
2.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах	Бүх албан хаагч нар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт даатгалаар болон сайн дураар жил бүр хамрагдаж ирсэн. 2022 он гарсаар “Эрүүл мэндийн эрт илрүүлэг” үзлэг шинжилгээний багцад хамрагдах албан хаагчдын судалгаагт насны бүлэгээр /31-45, 46-60, 61-с дээш/ гарган дүүргийн эрүүл мэндийн төвд хүргүүлээ. Албан хаагчид ажилтны эрүүл мэнд болон нийгмийн	100%

		асуудалд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд нүдний харааг шалгуулах болон бусад төрлийн үзлэг шинжилгээнд хамрагдах ажлыг зохион байгууллаа Ходоодны дуран, эхо, зүрхний бичлэг, Дох, сүрьеэ, БЗХӨ, зэрэг бусад үзлэг шинжилгээнд хамрагдлаа. Одоогийн байдлаар ноцтой буюу хүндээр өвчилсөн илэрц гараагүй бөгөөд жил бүрийн байгууллагын Албан хаагчдын нийгмийн баталгааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаад биелэлтийг тооцон ажиллаж байна.	
ХОЁР.АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ			
3.	Албан хаагч нарт ажиллах тав тухтай орчныг бүрдүүлэх	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй сарын аяны ажлын хүрээнд ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, ая тухтай орчинг бүрдүүлэх тал дээр дотоод хяналтыг зохион байгууллаа. Цахилгаан, дулаан, гэрэлтүүлэг, техник хэрэгсэл, ажлын эмх цэгц, ая тухтай орчин бүрдүүлэх зэрэг энгийн нөхцлийн дотоод хяналтыг зохион байгууллаа. Илэрсэн зөрчил үгүй. Гэрэлтүүлэгийн ламп шатсаныг сольлоо. Албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. 1 хүнд ногдох ажлын талбай, м3 хэмжээ хангалттай байдаг ба . дулаан алдалтыг арилгаж халаалтын регистер нэмж тавьснаар ажиллах орчин нөхцөл дулаан болсон.	100%
4.	Шаардлагатай компьютерийн техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахим орчны аюулгүй байдлыг хангах	Шаардлагатай техник хэрэгсэл, ажлын компьютер, бусад хэрэгслээр бүрэн хангагдсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй сарын аяны хүрээнд ажлын байрны эрүүл ахуй "Компютерийн зөв хэрэглээ, аюулгүй байдал зөвлөмж"-ийг өгч ажиллалаа.	100%

		<p>Компьютер дээр зөв суух</p>  <p>Цахим орчны болон ERP системийн юулгүй байдлыг ханган ажиллаж байна</p>	
ГУРАВ.АЛБАН ХААГЧДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНГ НЭМЭГДҮҮЛЭН, ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ			
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл болон хөдөлмөрийн гэрээг дүгнэж хамт олны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, ур чадвар үр дүнгийн урамшуулал олгох	Байгууллагын албан хаагч нарын ажлын гүйцэтгэл болон үр дүнгийн биелэлтийг сар бүр үнэлж хагас бүтэн жилээр үр дүнгийн тайланг хурлаар хэлэлцэн дүгнэж байна. Мөн хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ дотоод журмын дагуу дүгнэж ур чадварын болон үр дүнгийн урамшууллыг төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу олгож байна.	100%
6.	Байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловсруулж батлуулах	Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмаа боловсруулаад байна. Хөдөлмөрийн дотоод журамд Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт "Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ" гэх заалтын дагуу хөтөлбөр төлөвлөгөө гаргахаас гадна байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамдаа тусгаад байна.	100%
7.	Албан хаагч нарын ажлын гүйцэтгэл, үр дүн, ажилласан хугацаанд үндэслэн төрийн одон медаль, салбарын болон нийслэл, дүүргийн шагналуудад тодорхойлох	Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын Хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг Ардын хувьсгалын 101 жилийн ойтой хамтатган тэмдэглэх болсонтой холбогдуулан Улсад 30 гаруй жил ажиллаж байгаа 2 ахмад албан хаагчийг	100%

		Алтан гадас болон хөдөлмөрийн хүндэт медальд, 2 залуу боловсон хүчинг салбарын шагналд тодорхойлж 2022 оны байдлаар Төрийн болон салбарын шагнал хүртлээ.	
8.	Албан хаагчдын ар гэрт гачигдал гарсан тохиолдолд цалинтай чөлөө олгож, тусламж үзүүлэх	Албан хаагчдын ар гэрт гачигдал гарсан тохиолдолд дотоод журмын дагуу ажлыг зохицуулж цалинтай чөлөө олгох, тусламж дэмжлэг үзүүлдэг бөгөөд 2022 он гарсаар энэ төрлийн чөлөөг 1 албан хаагчид олгоод байна.	100%
9.	Албан хаагч 3 сараас дээш хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 43.3.4. дэх заалтыг үндэслэн албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлж, ажлын байрыг хэвээр хадгалж, мөнгөн тусламж үзүүлэх	Төрийн албаны тухай хуулийн 43.3.4. дэх заалтын хүрээнд хамаарах хөдөлгөөн, зохицуулалт хийгдээгүй байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1.3 дахь заалтын хүрээнд амаржсаны амралт, чөлөөтэй байгаа 1 албан хаагчийн ажил үүргийг хавсран гүйцэтгэх шийдвэрийг гарган ажиллаж байгаа бөгөөд орон тоо бүтэц бүрэлдхүүнд өөрчлөлт гараагүй хэвийн бүтэцээр ажиллаж байна.	100%
10.	Нийслэл болон дүүргээс зохион байгуулах нийгмийн хариуцлагын чиглэлийн үйл ажиллагаанд хамт олныг оролцуулах	Нийслэл болон дүүргээс зохион байгуулж буй нийгмийн хариуцлагын чиглэлийн үйл ажиллагаанд байгууллага, хамт олноороо идэвхтэй оролцож зохион байгуулалтын арга хэмжээг тайлан мэдээгээр албажуулан хугацаанд нь хүргүүлж хэвшсэн. Хавар, намрын болон улсын баярын өмнөх бүх нийтийн хог цэвэрлэгээ, хавар, намартаа мод тарих зэрэг ажил арга хэмжээнд хамрагдаж ирсэн. Мөн нийгмийн хариуцлагын чиглэлийн хүрээнд “Эрсдэлгүй амьдрал” архины хор хөнөөл сэдэвт сургалтыг Дүүргийн ИТХ-аас зохион байгуулсанд байгууллагаас 4 албан хаагч хамрагдаж нөлөөллийн арга хэмжээг дэлгэрүүлэх тал дээр ажиллалаа. Түүнчлэн 2022 онд зохион байгуулагдсан бусад аян, арга хэмжээнд хамрагдаж ирлээ.	100%

ДӨРӨВ.АЛБАН ХААГЧ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

11.	Албан хаагч нь 5 ба түүнээс дээш хоногийн танхимын сургалтанд хамрагдах тохиолдолд цалинтай чөлөө олгох	5 ба түүнээс дээш хоногийн танхимын сургалтанд хамрагдсан албан хаагч байхгүй	100%
Хэрэгжилтийн дундаж			100%

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХТОГТОХ